ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

БАТЛАВ.
ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ, ХОШУУЧ _____ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН
/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТ ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

2026 оны 10 дугаар сарын 14 Дугаар 001/33-12. Улаанбаатар хот

Бүх шатны боловсролын байгууллага,
хүүхдийн эмнэлгийн барилга байгууламжид
төлөвлөгөөт бус

Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

1.1. Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2026 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн “Хүүхдийн төлөө за бол заавал хийе” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж гамшгаас хамгаалах болон гал түймрийн эрсдэлийг бууруулахад оршино.

1.2.Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журам, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан зохион байгуулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтны хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

14261305 9

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтын хүрээнд зохион байгуулна.

2.4. Эрх бүхий албан тушаалтан нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, зөрчлөө арилгаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу холбогдох ажил, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга хариуцна.

Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд, барилга байгууламж

3.1. Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг бүх шатны боловсролын байгууллага, хүүхдийн эмнэлгийн барилга байгууламжийн иргэн, хуулийн этгээдийг хамруулна.

Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

4.1. Нийслэлийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч — Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч;

Гишүүд — Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар;

4.2. Орон нутгийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч — Төв орон нутгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, сумын Онцгой байдлын хэлтсийн дарга нар;

Гишүүд — Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гамшгаас хамгаалах

болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар.

4.3. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2026 оны 10 дугаар сарын 16-ний өдрөөс 11 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2027 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс 03 дугаар сарын 03-ний өдрийг хүртэл зохион байгуулна.

4.4. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн мэдээг 2027 оны 03 дугаар сарын 04-ний өдөрийн дотор тус тус хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудасны хамт Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн inspector.obeg@gmail.com, Ажиллагааны удирдлагын газрын disaster_inspector@nema.gov.mn цахим хаягаар тус тус ирүүлнэ.

4.5. Төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар, Ажиллагааны удирдлагын газар тус тус нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

Тав. Хариуцлага

Төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг удирдамжид заагдсан хугацаанд үр дүнгүй зохион байгуулсан гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч, тухайн газар хэлтсийн даргад хариуцлага тооцно.

---o0o---